

АСРАМЖИЙН ТӨВИЙН ХҮҮХДИЙН НИЙГМИЙН УР ЧАДВАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Г. Ойнбаяр

Докторант, ахлах ажилтан

*Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын
газар*

Oinbayar@fcy.gov.mn

Хураангуй: Халамжийн төвд амьдардаг өсвөр настны нийгмийн ур чадварыг тодорхойлж, чухам ямар дадал түүнд амар хялбар ба ямар дадал хүнд хэцүү байдаг талаар үнэлэх зорилгоор “Нийгмийн ур чадварын хөгжлийн түвшинг судлах” аргачлал бүхий 5 үзүүлэлтээр үнэлэн халамжийн төвд амьдардаг хүүхдүүдийн нийгмийн ур чадварыг судлан гэр бүлийн орчинд амьдардаг хүүхдүүдийн ур чадвар, өөрийгөө үнэлэх үнэлгээтэй харьцуулан үзсэн. Бидний судалгаанд “Өнөр бүл хүүхдийн төв”-ийн 12-17 насны 77 хүүхэд, Баянзрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн гэр бүлдээ амьдардаг 12-17 насны 77 хүүхэд оролцсон. Нийт 154 хүүхдийн 308 асуулгыг анкет, ярилцлагын аргаар авч харьцуулан гэр бүлийн орчинд амьдардаг хүүхэд, халамжийн төвд амьдардаг хүүхдийн нийгмийн ур чадварыг үнэлэн дүгнэлт гаргасан. Судалгааны үр дүн бидний дэвшүүлсэн таамаглалтай нийцсэн ба “Гэр бүлийн орчноос тусгаарлагдсан хүүхдийн нийгмийн ур чадвар гэр бүлдээ амьдарч буй үе тэнгийн хүүхдээс сул, нийгэмшлийн орчин хязгаарлагдмал” гэсэн дүгнэлт гарсан бөгөөд эдгээр хүүхдүүдийн нийгмийн ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Түлхүүр үгс: Харилцаа, хандлага, нийгэмшил, хөгжил

УДИРТГАЛ

Монгол улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтэнд өгсөн зөвлөмжийн дагуу үрчлэлт, хүчирхийлэл, үл хайхрах байдал, ёс бус харилцаа, амьдралын түвшин, гудамжны хүүхдийн асуудлаар тодорхой арга хэмжээг авч ажилласан ч хүүхдийн эрхийн зөрчил буурахгүй асран хамгаалагчгүй хүүхдүүд төвлөрсөн асрамжийн газар амьдарсаар л байна. Асрамжийн төвүүдэд бүтэн болон хагас өнчин, эцэг эх, асран хамгаалагч нь шоронд хорих ял эдэлж байгаа, архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүлээсээ тусгаарлагдсан, хараа хяналтгүй эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд амьдарч байна. Тэдгээр хүүхдүүдийг сум, хорооны нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн Засаг даргын захирамжийн дагуу асрамжийн төв хүлээн авдаг. Эцэг эхийн хараа хяналтгүй байгаа хүүхдүүд ихэнхдээ нийгмийн сөрөг дадал туршлагатай, биеийн болон сэтгэцийн доголдолтой, түүнчлэн хүмүүжлийн тогтворгүй байдалтай байдаг нь тэдний амьдралд ихээхэн нөлөөлж байна. Эдгээр

хүүхдүүдийн ур чадвар хийгээд нийгэмшлийн асуудлыг хөндөн халамж асрамжийн төвд амьдардаг хүүхдийн бие даан амьдрах чадварыг үе тэнгийн хүүхэдтэй нь харьцуулж гэр бүлдээ амьдарч буй хүүхдийн нөхцөл байдлын ижил болон ялгаатай талуудыг гаргаж амьдрах ур чадварын түвшинг үнэлж нийгмийн ур чадварыг нэмэгдүүлэх нийгэмшил, хөгжлийн үйлчилгээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. 2019 оны 1-р улиралын байдлаар асрамж, халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 21 байгууллага болон харьяа салбар төвүүд нийлээд нийт 31 төвд 1060 хүүхэд байна. Халамжийн төв нь хүүхдийн нийгэмд ажиллаж амьдрах байр сууриа олох гол загвар болох ёстой бөгөөд тэнд явуулж буй сургалт хүмүүжлийн ажлаас хүүхдүүдийн олж авах нийгмийн ур чадвар ихээхэн хамаардаг байна. Гэтэл төвлөрсөн халамжийн төвийг төгсөгчид бие даан амьдрах чадвар сул, практик болон материаллаг талын амьдралын зөв хэвшилд хангалттай суралцаагүй, орчин тойрныхоо хүмүүстэй харилцах харилцаа нь хүндрэлтэй, нийгмийн янз бүрийн сөрөг хандлагыг даван туулах чадвар сул, хувийн болон гэр бүлийн амьдрал зохиоход ихээхэн асуудалтай тулгардаг гэжээ³⁸. Үүнээс халамжийн төвийн уламжлалт сургалтын арга зүй, хандлага хүүхдийн нийгмийн ур чадварыг хөгжүүлдэггүй нь харагдаж байгаа тул байр орчныг гэр бүлд дүйцэхүйц орчин болгож өөрчилсөн байдал дангаараа хангалтгүй бөгөөд нийгэмшил хөгжлийн шинэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн нийт зохион байгуулсан арга хэмжээгээр биш хүүхэд нэг бүрийн ахиц дэвшлийг судлан хардаг өөрчлөлтийг хэмжиж чаддаг нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ ба багшийн ур чадварыг дээшлүүлэх тодорхой арга хэмжээг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн дараах зорилтыг тавьж судалгааг хийсэн. Үүнд: Халамжийн төвийн хүүхдэд нийгмийн ур чадвар хуримтлуулах онолын үндсийг түшиглэн амьдрал практикт хэрэглэх бүлгээр дамжуулан хөгжүүлж, нийгэмшүүлэх аргазүйг боловсронгуй болгох. Эдгээр зорилго болон төсөөллийн үндсэн дээр доорх судалгааны зорилтуудыг шийдвэрлэхийг зорьсон.

1. Халамжийн төвд амьдарч байгаа өнчин хүүхдүүдийн нийгмийн ур чадварын төвшинг тодорхойлж шалтгааныг тодруулах
2. Халамжийн төвийн сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэл арга хэлбэрийн үндэслэлийг тогтоох

Судалгааны таамаглал: Гэр бүлийн орчноос тусгаарлагдсан хүүхдийн бие даан амьдрах чадвар гэр бүлдээ амьдарч буй үе тэнгийн хүүхдийн амьдрах ур чадвараас сул, нийгэмшлийн орчин хязгаарлагдмал байна.

³⁸Invalid source specified.

СУДАЛГААНЫ ОНОЛ, АРГАЗҮЙ:

Энэхүү судалгааны ажлын онол, аргазүйн үндэс нь хүүхдийн нийгэмшил, хөгжлийн онцлог, нийгмийн ур чадвар зэрэг асуудлын хүрээнд тайлбарлагдсан. Мөн гадаад дотоодын энэ чиглэлээр хийгдсэн эрдэмтдийн судалгаа шинжилгээ, баримт бичгийн дүн шинжилгээ, мэдээлэл цуглуулах болон тоон болон чанарын аргуудыг хэрэглэсэн. *Орчин үеийн нийгмийн тухай ном зохиолд нийгмийн ур чадвар гэдэг ойлголт нь нийгэмших гэдэг ойлголттой дандаа хамт явдаг*³⁹ гэжээ. *Нийгэмшинэ гэдэг нь: Мэдэрсэн туулж өнгөрүүлсэн аль эсвэл хүлээн авсан нийгмийн туршлагын механик тусгал биш юм. Энэхүү туршлага нь субъектив хүчин зүйлсээс ихээхэн хамаардаг байна. Өөрөөр хэлбэл хүн бүр ижил нөхцөл байдлыг янз бүрээр хүлээн авдаг. Бие хүн бүр ижил нөхцөл байдлаас харилцан адилгүй нийгмийн туршлагыг хуримтлуулдаг байна. Нийгмийн ур чадварыг эзэмших гэдэг нь: Орчин тойрны хүнд үзүүлэх нөлөө, нөгөө талаасаа хүн өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан орчин тойрондоо үзүүлэх нөлөөг хэлнэ*⁴⁰. *Хүүхдэд нийгмийн ур чадвар эзэмшүүлэхдээ дараах ойлголтуудын хүрээнд мэдлэг хуримтлуулж хувийн ур чадвараа нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Үүнд эхлээд нийгэмшил, нийгмийн ур чадвар, амьдрах ухааны суурь ойлголтуудыг хамруулах ба эдгээр ур чадварын гол чиглэл нь хүний хүнтэй харилцах болон нийгмийн харилцаанд оролцох байдлаар ур чадварууд үнэлэгднэ. Нийгмийн ур чадвар гэдэг нь: (Social Skill), (Социальные навыки) Арга зүй зан байдлын зарчим хэм хэмжээ, ёс суртахууны дүрэм журам, улалжлал, зан заншил, зан үйл үүргийн тухай ойлголт дээр тулгуурласан хүмүүсийн хамтын үйл ажиллагааны туршлагыг хэлнэ. Ингэхдээ хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэг соёлоор илэрдэг байна*⁴¹. *Нийгмийн ур чадвар гэдэг нь: Хүн орчинтойгоо харилцах идэвхтэй үйл ажиллагааны үр дүн байдаг. Нийгмийн ур чадварыг хуримтлуулах: Мэдээлэл хэв маягийг өөрийн болгоод зогсохгүй үйл ажиллагаа ба харилцааны арга хэлбэрийн үр дүн болсон дээрх туршлагыг өөрийн болгон суралцахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл хүн бүр нийгмийн ур чадварыг эзэмших бүр цаашлахад өөрийн болгоход оршино. Хувь хүний нийгмийн ур чадвар гэдэг нь хувь хүний төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцсон туршлага бөгөөд энэ нь түүний амьдралыг ойлгоход өөрийн ул мөрөө үлдээж амьдралын мэдлэгийн*

³⁹ (Кон, И. С. Социология личности [Текст] / И. С. Кон. – М.: Изд-во «Политиздат», 1967. – 383 с.)

⁴⁰ Invalid source specified.

⁴¹ Invalid source specified.

агуулгыг тодорхойлсон бүхий л талд хандах хандлага ба дадал чадварын хөгжлийн түвшинг хэлнэ⁴².

Нийгмийн ур чадварын ангилал:

1. Амьдрах чадвар чадвар:(Survival skills)- Хүнтэй харилцахдаа өөртөө итгэлтэй байх, өөрийгөө урамшуулах, бусдад уруу татагдахгүй байх, дүрэм журам, дагаж мөрддөг сонсох чадвар.
2. Харилцааны чадвар:(Interpersonal skill)-Санаа бодлоо хуваалцах, зөвшөөрөл авах, үйл ажиллагаанд оролцох, ээлжээ хүлээх дараалалд суралцах чадвар.
3. Асуудлыг шийдвэрлэх чадвар:(Problem-solving skills)-Тусламж, уучлалт хүсэх, үр дагаварыг хүлээн зөвшөөрөх, юу хийхээ шийдэх
4. Зөрчлийг шийдвэрлэх чадвар:(Conflict resolution skills)- Тоглоом тохуу хийх, урам хугарах, хожигдох зэрэг асуудлыг зохицуулах, үе тэнгийн дарамт, хожигдол, хаягдах мэдрэмж, хэн нэгэн хүн буруутгах, зэмлэх зэрэг сөрөг мэдрэмжийг даван туулах, хариу үйлдэл үзүүлэх чадвар⁴³.

Нийгэмшилтийн үйл явцын мөн чанар нь нийгмийн янз бүрийн үүрэг роль гүйцэтгэсэн өөрийн гэсэн нийгмийн ур чадвар хуримтлуулсны үр дүнд бие хүн болж төлөвшихийг хэлнэ⁴⁴. Нийгмийн ур чадвар гэдэг түүний арга зүй зан байдлын зарчим хэм хэмжээ, ёс суртахууны дүрэм журам, улалжлал, зан заншил, зан үйл үүргийн тухай ойлголт дээр тулгуурласан хүмүүсийн хамтын үйл ажиллагааны туршлагыг хэлнэ. Ингэхдээ хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэг соёлоор илэрдэг байна⁴⁵. Бид амьдралынхаа туршид өөрийн ухамсарлаагүй хэдий ч нийгмийн ур чадвараа солилцож байдаг. Хэрэв энэ солилцоо явагддаггүй байсан бол хүн бус амьтан байх байсан ба аль эсвэл амьдрах чадваргүй байх байсан. Хувь хүн нийгмийн ур чадвар хуримтлуулах замаар бие хүн болж төлөвшдөг. Нийгмийн шинжүүд нь удам дамждаггүй түүнийг нийгмийн ур чадвараар эзэмшихэд хүргэдэг. “Нийгмийн амьдралд өөрийн байр сууриа олно” гэдэг зөвхөн мэдлэг мэдээлэл, чадвар, чадавхи эзэмшихээр тогтохгүй чухам өөрийг нь бий болгож байгаа тэр л үйл ажиллагааны арга хэлбэр, харилцааг эзэмшихийг хэлнэ. Хүүхдийн нийгмийн ур чадвар гэдэг нь түүний нийгэмшилт болон олж авсан хүмүүжлийн үр дүн юм.

⁴² (Морозова, И. В. Детский дом как социализирующая воспитательная система – 2011. – №6. – С. 49 – 54.)

⁴³ **Invalid source specified.**

⁴⁴ (Куренкова, О. Е. Формирование социального опыта у студентов педвуза в учебной деятельности [Текст] : дис. канд. пед. наук / О. Е. Куренкова. – Вологда, 2002. – 172 с.)

⁴⁵ **Invalid source specified.**

Нийгмийн ур чадвар хуримтлуулах явдал нь 3 харилцан холбоотой замаар явагддаг.

1/. Энэ нь урсгалаараа явагддаг. Хүүхэд төрснөөсөө эхлэн амьд амьтан, нийгмийн нэг гишүүн болон нийгмийн үйл ажиллагаанд оролцдог байна. Ингэхдээ хүүхэд зүгээр орчин тойрныхоо нөлөөнд автах биш харин бусад хүмүүстэй тодорхой харилцаанд орсны үр дүнд нийгмийн туршлагыг хуримтлуулж эхэлдэг байна.

2/. Нийгмийн ур чадварыг тодорхой чиглэлээр олж авах зам. Үүнд: “Хүмүүжлийн ажил”, боловсрол, сургалтаар дамжуулан нийгмийн ур чадвар олгодог.

3/. Санамсаргүйгээр олж авах. Хүүхэд амьдралынхаа бүр эхэн буюу нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах чадваргүй үе ч амьдралын тодорхой нөхцөл байдал, орчин тойрныхоо хүмүүст маш хурдан дасан зохицох чадвартай байдаг байна.

Өнчин, эцэг эхийн халамжгүй болсон хүүхдүүдийн нийгмийн ур чадвар хуримтлуулах явдал нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг. Морозова, И. В, Курникова нарын судалгаанаас харахад хүүхдийг халамжийн төвөөр дамжуулан өсгөн хүмүүжүүлэх нь түүний амьдралын үндсэн хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй. Энэ нь хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг байна. Халамжийн төвд өссөн хүүхдүүд бие даан амьдрах чадваргүй, ажил хайж олж авах, ажилгүйдлийн үед түүнийгээ хадгалах, өөрийн амьдрал ахуйгаа чөлөөт цагаа зөв зохион байгуулах, гэр бүлтэй болох түүнийгээ авч явах чадваргүй байдаг байна.

Хүүхдийг бие хүн болж төлөвшихөд өөрийгөө илэрхийлэх чадвар, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг чадвараас гадна өөрийгөө танин мэдэх, өөрийн үнэлэмжийг бодитой болгох аргад суралцуулах нь зайлшгүй шаардлагатай. Үүнд мөн Л.И. Божович, А.М. Прихожан нарын халамжийн төвийн хүүхдүүдийн зан суртахууны доголдлыг судалсныг үзэхэд улсын төвлөрсөн халамжинд амьдардаг хүүхдүүд нь тэндээс сөрөг зан үйл, хуримтлуулдаг нь тогтоогдсон байна.

Түүнчлэн хүүхдүүдийн зарим нэгэн сэтгэлзүйн шинж чанарууд нь тэдгээрийг нийгмийн ёс бус үйлдэл, гэмт хэрэгт хөтөлдөг байна. Эдгээр шинж чанарууд нь маргаантай асуудлыг шийдвэрлэхэд хоорондын харилцааг бий болгох нөхцөлд, бие хүний сэтгэл зүйн хувьд тогтворгүй байх, бодит бус өөрийн үнэлэмжтэй байх, удирдах чадвар сул, аливаад түрэмгий хандах сэдэл өндөртэй байх зэргээр илэрдэг байна. Халамжийн төвийн сонгодог системд эдгээр хүүхдүүд нь нийгмийн зан суртахууны дутагдалд орох магадлал нэн өндөр байдаг байна. Энэ нь эргэн тойрондоо олон хүнтэй харилцах хүрээ хязгаарлагдмал, харилцах орон зай явцуу, мэдээлэл хүлээн авах боломж хомс, нийгмийн боломж бага байдагтай холбоотой байдаг байна.

Халамжийн төвийн үйл ажиллагаанд эцэг эхийн хайр энэрэл, хайр дутагдсан өнгөцхөн харилцаа нь сэтгэл зовних, өөртөө итгэлгүй байдлыг өдөөх, идэвхитэй танин мэдэх бүтээлч үйл ажиллагааг бууруулдаг. Өнчин хүүхдүүд өөрсөдтэйгээ ижил нөхцөл нийгмийн ур чадвартай хүүхдүүдтэй нэгдэх сонирхолтой байдаг нь тэдгээрийн тэдэнтэй харилцах бие авч явах байдалд амар байдагтай холбоотой. Эдгээр албан бус бүлэглэлд тогтсон дэг жаяг байхгүй, хөдөлмөр хийх үнэ цэнэ бага хичээл номондоо хоцрох нь энгийн үзэгдэл, эрдэм ном мэдлэг, хөдөлмөрийн чадварын үнэ цэнэ гэхээсээ илүү эр зориг авхаалж самбаа зэрэг хүчний талуудыг өндөрт өргөдөг нь илүү үнэлэгддэг тул өөртөө илүү татдаг байна. Албан бус бүлэглэлүүдийн нөлөөгөөр бүрэг даруу хүүхдүүд бүдүүлэг авирлах, хичээнгүй хүүхдүүд сурлагаараа хоцрох, нээлтэй хүүхдүүд нь ноомой дуу муутай болох зэргээр өөрчлөгддөг байна. Бүлэглэлүүд өөрийн эзэмшлийн газар нутгаа зодоон цохионы замаар бусдын нөлөөнөөс хамгаалдаг байна. Хүүхдийн эдгээр бүлэглэл нь гэмт хэргийн туршлагатай хүний нөлөөн дор гэмт хэргийн шинжтэй болох аюул байдаг байна. Ялангуяа хараа хяналт сул амьдрал нь өөрийн урсгалаар явдаг халамжийн төвийн хувьд аюул илүү нүүрлэж байдаг.

Халамжийн төв хүүхдэд нийгмийн ур чадвар эзэмшүүлэхэд тулгардаг асуудал ба хүүхдэд гардаг сөрөг хандлагуудын учир шалтгааныг олоход чухал юм. Тухайлбал: Хүүхдүүдтэй харилцах томчуудын харилцаа дутагдах буюу тэдгээрийн хэлбэр оновчгүй байх явдал нь үр хүүхдэд үзүүлэх үр нөлөө багатай байдаг. Энэ нь ялангуяа эцэг эхийн халамжгүй өсөж буй халамжийн төвүүд сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагад ихээхэн хамааралтай. Манай оронтой адилхан төвлөрсөн халамжийн үйлчилгээ үзүүлдэг ОХУ-ын эрдэмтэд халамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийн 80% нь хөгжлийн ямар нэг гажуудалтай эсвэл эрүүл мэнд нь сул, бие даасан байдал муутай, бэлэнчлэх сэтгэлгээтэй байдаг⁴⁶ гэжээ. Халамжийн төвийн төгсөгчид ихэнхдээ нийгмийн ур чадвар хангалттай эзэмшээгүй бие даан амьдрах чадвар сул, харилцаа холбоо муутай болсон байдаг нь өмнөөс нь нийгмийн ажилтан асуудлыг шийдвэрлэж амьдралд тулгарч болзошгүй эрсдлүүдийг тайлбарлах хүн байгаагүй гэж үздэг. Энэ хандлага төгсөгчдийн судалгаа болон бүлгийн ярилцлагаар илэрдэг. Тэд нийгмээс тусгаарлагдсан гэсэн мэдрэмжтэй, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож чаддаггүй. Энэ нь ихэнхдээ гэр бүлийн орчин нөхцөл бүрэлдээгүй халамжийн төвд хүмүүжсэнээс үүдэлтэй байдаг. Халамжийн төв хүүхдийн аюулгүй байдлыг ханган амьдрах таатай нөхцлөөр хангахын зэрэгцээ хүүхдийн нийгэмшил, хөгжилд бүрэн анхаарч хүүхэд нэг бүрийн өөгчлөлт хөгжлийг хэмжин нийгмийн ур чадвар

⁴⁶ Invalid source specified.

эзэмшүүлэх шаардлагатай. Хүүхдүүд сэтгэл зүйн хувьд хүмүүсээс тусгаарлаж хөндийрсөн нь гэмт хэрэг, зөрчил үйлдэх алхам болдог. Хайр, энхрийлэл дутагдах хүмүүний хэвийн харилцааны эерэг сэтгэл хөдлөл багадсанаас гар хангалга хийх, ижил хүйстнээ сонирхох зэрэг бэлгийн буруу хандлага төлөвшдөг. Түүнчлэн “бидэнд өгөх ёстой” “бидэнд өг” гэсэн тэжээврийн сэтгэхүйтэй болж, арвич хямгач байх, хариуцлага, амьдралын материаллаг талыг ойлгох, хувийн өмч, хямгадах талаар ойр зуурын ч мэдлэггүй болж өсдөг байна. Төвлөрүүлэн асрах төвд хүүхдүүдэд өөрөө өөртэйгээ байх цаг гардаггүй. Иймээс тэдний өөрийн ухамсараа хөгжүүлэх, өөрөө өөртэйгээ ажиллах боломж, бололцоо байдаггүй. Сэтгэхүйн хувьд тусгаарлан ганцаараа байж чаддаггүйгээс том хотод амьдардаг халамжийн төвийн хүүхдүүд сэлгүүцэх нь элбэг. Энэ нь даамжраад оргон зайлах, тэнүүчлэхэд хүргэдэг. Зөрчилдөөний үед өөрийн бурууг хүлээж чаддаггүй буюу хүсдэггүй /зөрчилдөөний үед биеэ хамгаалах зан байдал давамгайлдаг/, бие дааж өөрийн үйлдэлээ төлөвлөх буюу хянах чадвар сул, өөрөөр хэлбэл, тухайн нөхцөл байдалд тааруулж шийдвэр гаргах биш гадны хяналтанд тулгуурлах хандлага давамгайлдаг. Бэрхшээлийг өөрөө даван туулах биш гомдоллох, хариуцлагаа бусдад тохохыг урьтал болгодог. Тэдний танин мэдэх эрмэлзэл буурсан байдаг. Улсаас бүрэн санхүүждэг төвлөрсөн төвд байдаг нь тэднийг тэжээврийн сэтгэхүйтэй болгож, өөрийнхөө хүрээнд ч амьдралын материаллаг талыг ойлгодоггүй, хувийн өмчийн талаар ямар ч мэдлэггүй, арвилан хэмнэхийг хичээдэггүй болгодог. И.В.Дубровина, А.Г.Рузской нарын судалгаанууд төвлөрүүлэн асрах төвийн хүүхдүүд өөрийн гэр бүл зохиох, хадгалахад ихээхэн бэрхшээлтэй тулгаран хадам аав, ээжтэйгээ хэл ам ололцохдоо муу, хань ижилтэйгээ бүрэн дүүрэн харилцаа үүсгэж чаддаггүй байна. Анхны дотносол амархан дуусч, ханьтайгаа харилцах харилцаа нь удаан үргэлжилдэггүй байна⁴⁷. Өнчин хүүхдүүд гэдэг нь хүн амын нийгмийн хувьд хамгааллагдаагүй, эрсдэлд амархан өртдөг бүлгийг хэлэх ба сэтгэл хөдлөлийн харилцаа холбоо бага, томчууд болон үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцаа нь бэрхшээлтэй, сэтгэцийн бэлгийн чиг бүрэлдэн тогтоход хүндрэлтэйгээс үүдэн нийгмийн орчинд дасан зохицохдоо тааруу байдаг. Эдгээр хүүхдийн ихэнхид нь девиант зан үйл /оргох, хулгай хийх, эргэн тойрныхондоо хатуу ширүүн хандах зэрэг нийгмийн эсрэг үйлдлүүд/ илэрдэг байна. Нийгэмшүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагаа нь эдгээр доголдолоос урьдчилан сэргийлэх, засан чиглүүлдэг байх ёстой ба төвлөрсөн халамжийн төвийн орчинд нийгэмшүүлэх ажлыг төгөлдөржүүлэх үүрэгтэй. Үүнд, ялангуяа тоглоомын арга нь тохиромжтой

⁴⁷ Invalid source specified.

бөгөөд бага насны хүүхдүүдэд сургалтын арга хэлбэрийн хамтаар үндсэн аргад тооцогддог байна.


Хүүхдийн хөгжлийн онцлог, эрсдлийн түвшний судалгаа

Халамжийн төвд амьдардаг хүүхдийн нийгэмшил, амьдрах ур чадварыг судлан “Өсвөр настны нийгмийн ур чадварын төлөвшсөн байдлын түвшин”-г тодорхойлох, чухам ямар дадал түүнд амар хялбар ба ямар дадал хүнд хэцүү байдаг талаар үнэлэх зорилгоор “**Нийгмийн ур чадварын хөгжлийн түвшинг судлах**” аргачлалаар эхний судалгааг “Улсын төсвөөс санхүүждэг” “Өнөр бүл хүүхдийн төв”-ийн 12-17 насны 77 хүүхдээс “Өөрийн болон үе тэнгийн хүүхдийн нийгмийн чадамжийн судалгаа” авч Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн гэр бүлдээ амьдардаг 12-17 насны 77 хүүхдээс, авсан судалгаатай харьцуулан нийгмийн чадамжийн үнэлгээ хийлээ. Нийт 154 хүүхдийн 308 асуулгыг анкет, ярилцлагын аргаар авч боловсруулалт хийсэн. Үүнд:

1. Анхан шатны чадамжууд- Хүний бусад хүмүүстэй харилцаанд орох, ярианд оролцох энгийн чадварууд
2. Өөрийгөө илэрхийлэх байдал. Өөрийнхөө сэтгэл санааг илэрхийлэх чадвар, мэдээллийг бусдад дамжуулах чадвар.
3. Хүний санал бодол, сэтгэл хөдлөлд хариу үйлдэл үзүүлэх байдал
4. Өөрийнхөө хийх үйлдлийг төлөвлөх чадвар. Хэн нэгэнтэй ярилцхаас өмнө болон ямарваа нэг зүйлийг хийхээс өмнө түүнийгээ төлөвлөх урьдчилан бэлтгэх байдал.
5. Түрэмгий байдлаас гарах чадвар. Харилцааны зөрчлөөс зайлсхийх, зөрчилд хүргэхгүй байх, түүнээс өөрийгөө авч гарах чадвар.

Эхний шатанд тухайн өсвөр насны хүүхэд дурьдсан чадамжуудыг хэрхэн гүйцэтгэх чадварыг тогтоож, **2 дахь шатанд** тухайн оролцогчийн үе тэнгийн хүүхдүүд тодорхой ур чадварыг хэрхэн эзэмшснийг тодорхойлж мэдээллийг боловсруулан үр дүнг нь тооцож чанарын дүн шинжилгээ хийсэн. А.П Гольштейний гаргасан 5 чадамж бүхий 37 асуулгаар 2 үе шаттай судалгаа авч мэдээллийг боловсруулан өөрийн нийгмийн чадварыг, үе тэнгийнхээ хүүхдийн нийгмийн чадвартай харьцуулж халамжийн төвийн хүүхдийн зан байдлыг судлан үр дүнг харьцуулан илэрхийллээ.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан оролцогчдыг хүйс, насны бүлгээр үзвэл:




40.1 хувь буюу 73 нь 10-12 насны хүүхэд, 35.6 хувь буюу 65 нь 13-15 насны хүүхэд, 24.3 хувь буюу 44 нь 16-18 насны хүүхдүүд байна.

Судалгаанд оролцсон 362 хүүхдийн 210 буюу 58.1 хувь нь эмэгтэй, 152 буюу 41.9 хувь нь эрэгтэй оролцогч байна.

Өөрийгөө илэрхийлэх чадвар нь хэл ярианы хөгжил, төгсөөд бие даан амьдрах чадвар сул байгаагийн шалтгаан нь нийгмийн ур чадварын хөгжил сул байгаатай холбоотой байна.

Судалгаанд оролцогчдын эхний бүлэг асуултын дунджаар ЕБС-ийн хүүхдүүдийн хамгийн өндөр 36 хувь нь ихэвчлэн, 25 хувь нь дандаа болон заримдаа, 3 хувь нь хэзээ ч үгүй гэж хариулсан бол халамжийн төвийн хүүхдүүдийн хамгийн өндөр 29 хувь нь заримдаа, 28 хувь нь хааяа, 15 хувь нь хэзээ ч үгүй гэж хариулсан байна. Хүмүүстэй ярианд оролцдог анхан шатны чадвар нь гэр бүлийн орчинд амьдардаг хүүхдийн хувьд өндөр байхад халамжийн төвийн хүүхдүүд энэ тал дээр асуудалтай буюу хэзээ ч ярианд оролцохгүй байх магадлал өндөр байгаа нь нийт хүүхдийн хувьд өөрийгөө илэрхийлэх, санаа бодлоо хуваалцах зэрэг харилцааны энгийн чадварыг сургах хэрэгцээ шаардлага их байгааг илэрхийж байна

Зураг 2. Ярианд өөрийгөө илэрхийлэх, өөрийн санаа бодол мэдрэмжээ илэрхийлэх, мэдээллийг өөр хүнд дамжуулах: Асуулт (5-13)




Өөрийн үнэлгээ болон үе тэнгийн үнэлгээг харьцуулж харвал өөрийгөө үнэлэхдээ хэзээ ч үгүй 1,5 функтаар их, хааяа 2,3 функтаар их, заримдаа 0,3 функтаар бага, ихэвчлэн 2,3 функтаар бага, дандаа 1,2 функтаар бага харагдаж байгаа нь өөрийгөө үе тэнгийхнээсээ доогуур үнэлэх хандлагатай байна. Үүнээс үзэхэд: Халамжийн төвийн хүүхэд бусадтай ярианд оролцох харилцах энгийн чадвар сул ба бусад

хүүхдүүдийг өөрөөсөө илүү гэж үнэлсэн байхад, гэр бүлийн орчинд амьдардаг ижил насны хүүхдүүд энэ чадвар илүү өндөр байна.

Хүмүүстэй ярилцахдаа өөрийгөө илэрхийлэх байдал гэр бүлийн орчинд амьдардаг хүүхдийн хувьд хүндрэл багатай байхад, халамжийн төвийн хүүхдүүд энэ чадвар төлөвшөөгүй заримдаа юмуу хааяа тохиолддог ба өөрийгөө илэрхийлэх чадвар муу байдаг байна. Энэ нь уур бухимдлаар асуудал шийдэвлэх сөрөг талтай байдаг.


Зураг-3 Бусдын санал бодолд хариу үйлдэл үзүүлэх Асуулт (14-22)



Харилцан ярилцаж буй хүндээ хариу үйлдэл үзүүлэх тал дээр гэр бүлийн орчинд амьдардаг хүүхдүүд онцгой ач холбогдол өгсөн байхад халамжийн төвийн хүүхдүүдэд энэ ур чадвар төлөвшөөгүй ба заримдаа юмуу хааяа л бусдад анхаардаг байна. Харилцааны явцад хариу үйлдэл үзүүлэх нь эерэг харилцааны шинж бөгөөд таньдаг таньдаггүй ямар ч хүнтэй соёлтой сайхан харилцаж холбоо тогтоох, хариу үйлдэл үзүүлэх чадвар хүний амьдралд ихээхэн чухал байдаг. Бусадтай холбоо тогтоох чадвартай байна гэдэг нь хүн насан туршийн амьдралдаа хүмүүстэй харилцаж түүний үр дагаварыг ойлгодог. Гэтэл судалгаанд оролцогч хүүхдүүдийн бусдын санаа бодол хариу үйлдэл үзүүлэх чадваруудын асуултын дундаж үнэлгээгээр өөрийгөө үнэлэхдээ 7,5 хувь нь хэзээ ч үгүй, 16,7 хувь нь хааяа, 28,7 хувь нь заримдаа гэж хариулсан тул халамжийн төвийн хүүхдийн 50 с дээш хувьд дараах чадварыг

эзэмшүүлэх тусгай хөтөлбөр зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Зураг 4: Хийх гэж буй үйлдлээ төлөвлөх чадварууд: Хэн нэгэнтэй ярилцахын өмнө болон аливаа зүйлийг хийхийн өмнө түүнийгээ төлөвлөх бэлтгэх чадвар: Асуулт (23-29)



Төлөвлөлт бол хэзээ юу хийхээ тодорхойлох чадвар ба хүсэн хүлээж буй ирээдүйгээ Хийх гэж буй зүйлээ төлөвлөх чадвар гэр бүлдээ амьдардаг хүүхдийн хувьд өндөр байхад хэзээ ч төлөвлөлт хийдэггүй гэсэн хариултыг халамжийн төвд амьдардаг хүүхдүүд илүү ихээр сонгосон байна. Судалгаанд оролцогч хүүхдүүдийн хийх үйлдлээ төлөвлөх чадваруудын асуултын дундаж үнэлгээгээр өөрийгөө үнэлэхдээ 9,2 хувь нь хэзээ ч үгүй, 17,5 хувь нь хааяа, 28,3 хувь нь заримдаа, 25,2 хувь нь ихэвчлэн, 19,8 хувь нь дандаа гэж хариулсан нь мөн л 50 с дээш хувь нь төлөвлөх чадваргүй ба цөөнх нь энэ талаар мэдэж 20 хүрэхгүй хувь нь төлөвлөдөг байна.

Зураг 6. Харилцааг нураах зөрчлийг зогсоох болон зөрчилтэй нөхцөл байдлаас гарах үр дүнтэй аргыг олох: Асуулт (30-37)



Зөрчлийг үийдвэрлэж эерэг харилцах нь хүний бие даасан чанар бөгөөд мэдээлэл дамжуулах, өөрийгөө илэрхийлж бусдыг ойлгох санаа бодол мэдрэмжээ илэрхийлэх зэрэг өргөн хүрээнд ашиглагддаг үндсэн чадвар бөгөөд энэхүү чадвар дутмаг зөрчлийг шийдвэрлэдэггүй хүүхдийг нэн тэргүүнд анхаарч эерэг харилцааны талаар сургалт хийж, зөрчлийг шийдвэрлэх арга зүйл сургах хэрэгцээтэй байна. Зөрчлийг зогсоох чадвар гэр бүлдээ амьдарч байгаа хүүхдийн хувьд өндөр байхад халамжийн төвд амьдарч буй хүүхэд зөрчлийг шийдвэрлэх зогсоох асуудал ач холбогдолтой зүйл биш байгаа нь энэхүү хэсгээс анхаарал татаж байна.

Хүүхдийн нийгмийн ур чадварыг үнэлсэн энэхүү судалгааны дүгнэлт 5 үзүүлэлт бүрээр гэр бүлийн орчинд амьдардаг хүүхдийн нийгэмшил хөгжлийн байдал халамжийн төвийн хүүхдээс илүү байна. Мөн халамжийн төвийн хүүхдүүд хэн хэгэнтэй ярианд оролцож өөрийгөө илэрхийлэх чадвар, бусдад туслах, төлөвлөх, зөрчлийг шийдвэрлэх зэрэг нийгмийн ур чадвар дутмаг байна.

Иймд: Халамжийн төвийн хүүхдүүд өөрийн ур чадварыг үе тэнгийн хүүхдээс сул дорой гэж үнэлдэг хандлагыг өөрчилж, нийгэмших хүмүүжлийн системийг бүрдүүлэхэд тулгарах бэрхшээлүүдийг онцгойлон авч үзэн бие даасан амьдралаа эхлүүлж буй залуу хүнд нийгэм ямар шаардлага тавихыг урьдчилан төсөөлж нийгмийн ур чадварыг хөгжүүлэх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд гарч байна.

Өнчин хүүхдүүдэд зохих үр дүнтэй нийгмийн ур чадварыг хуримтлуулахад аливааг бодитоор үнэлэх, өөрийгөө зөв үнэлэх чадвар суулгахын тулд тухайн хувь хүнд дараах чадварыг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нар суулгасан байх хэрэгтэй.

-Харилцааны соёл, биеэ зөв авч явах дадал хэвшүүлэх.

-Өөрийн сонголтоо ухамсартай, хариуцлагатай хийх чадвар суулгах

-Амжилтанд хүрэх үйл ажиллагаа ерөнхий түгээмэл чадваруудад сургах, өөрийн авьяас чадвар, хүрэх гэж буй зорилгоо үнэлж дүгнэх, өөртөө зорилго тавих, амжилт олоогүй тохиолдолд түүний шалтгааныг олж тогтоох чадвар г.м.

-Шинэ санаа, санаачилгыг дэмжих, бүтээлч чадваруудыг хөгжүүлж /асуудлыг шийдвэрлэх чадвар/ асуудлыг зөв томьёолж шийдэх чадвар, шийдвэр гаргахдаа уян хатан өвөрмөц арга замыг олох гм хүүхдийн нас хөгжлийн онцлогт тохирсон нийгмийн ур чадвар эзэмшүүлэх нь чухал байна.

Түүнчлэн маргаанаас хол байлгаж, зурагтаар хүчирхийллийг аль болох бага үзүүлэн, гудамжны дэггүй хүүхдүүдээс хамгаалах шаардлагатай. Гэхдээ ихэнх стрессийн нөхцөлийг тойрч гарах боломжгүй юм. Цаг хугацаа өнгөрөх тусам хүүхдүүд амьдралын

жирийн үзэгдлүүдийг хэвийн хүлээж авах чадварт суралцах хэрэгтэй. Үүнд:

1. Хүүхдийн стрессийн хариу үйлдлийг таньж, тайлбарладаг байх
2. Хүүхдийн өөртөө итгэх итгэлийг буцаахын тулд найдвартай, дулаан байх байраар хангах
3. Хүнтэй зовлонгоо хуваалцахад стресс тайлагддаг тул хүүхдээр юу тохиолдсон тухай, юу мэдэрч байгааг нь яриулах
4. Регрессив буюу насанд нь тохироогүй үйлдэл хийхийг нь хориглохгүй байх. Жишээлбэл: хуруугаа хөхөх дур, орны бүтээлгээр биеэ хучих, хэрэгтэй хэрэггүй зүйл асууж лавлах, өвдгөн дээрээ суух
5. Үйл явдал, нөхцөл байдлын талаар ойлгож мэдэхэд нь тусалж, тайлбарлах, мэдээлэл өгөх

Халамжийн төвийн нөхцөл байдал нь хамтарч амьдрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд ая тухтай байж эрүүл нэгдэл бий болгоход түлхэц болох ёстой. Үүнд:

- Төвүүд нь эрүүл, бүтээлч уур амьсгалыг бүрдүүлэх ёстой бөгөөд ингэснээр хүүхдүүдэд эерэг үнэт зүйлсийг бататган хүүхдийн зөвлөл нь багш нартаа шадар туслах нь болж өгөх хэрэгтэй.
- Хүүхдийн төвүүд нь тэднийг ирээдүйн бие даасан амьдралд бэлтгэж, өөрийн мэргэжлийн өсөлт дэвжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх замаар төвд амьдарч буй хүүхдүүдэд нийгмийн ур чадварыг хуримтлуулахад чиглэгдэх

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

Асрамжийн газар гэр бүлийг орлож чадахгүй ч ямар нэг хэмжээгээр хүүхдийг нийгэмд дасан зохицох болон нийгэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой.

Өнөөгийн нийгэмд тулгарч буй томоохон асуудлын нэг нь өнчин хүүхдүүдийг нийгмийн амьдралд бэлтгэн зөв хүн болгон төлөвшүүлэх явдал юм. Энэхүү үүргийг хүлээж буй төвүүдийн сургалт, хүмүүжлийн арга, хүүхдийг нийгмийн амьдралд бэлтгэх, амьдрах ухааныг сургах чиглэлээр явагддаг ч хэрэглэгч болох хүүхдийн бодит ур чадвар, санал хүсэлтийг сонсч судалгаанд суурилаагүй тул хүүхдийн хүмүүжлийн асуудал тулгамдсан асуудал хэвээр байгаа тул хувь хүнийг нийгэмшүүлэх, ур чадвар олгох шинэлэг үйл ажиллагааг нэвтрүүлэх шаардлагатай байгаа нь бидний судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Асран хамгаалагчгүй, бүтэн өнчин, үрчлэгдэх боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг төвлөрсөн халамжид үлдээн бие даан амьдрах боломжоор хангах, амьдралд суралцах хөтөлбөрт хамруулж хүүхдийн нийгэмшил хөгжлийн үйлчилгээг дэмжин ажиллаж байгаа нь

сайшаалтай ч хүүхдүүд өөрийгөө илэрхийлэх өөрөө шийдвэр гаргах боломж хомс байна. Үндсэндээ бол сургалтын тогтолцоонуудын үр дүнг тооцох ерөнхий аргачлал боловсруулж хандлага, баримжааг харуулсан социологийн судалгаа дээр үндэслэсэн үйл ажиллагаа зохион байгуулах. Халамжийн төвийн хүүхдийн хүмүүжлийн ажлыг сэргээхэд хүнлэг ёс дээр үндэслэн, үйлчилгээний сэтгэхүйг системчлэснээр инновацийн үйл явцыг хурдасгах явдал чухал юм.

Өнчин хүүхдүүдийг асардаг төвд бүрэлдэн тогтдог нийгмийн ур чадварын өмнө тулгардаг асуудал бол хүүхдийн нийгэмшил хөгжлийн үзүүлэлт ба тэд төгсөөд бие даан амьдрах үеэс эхлэн хүүхдэд хүндрэл үүсдэг. Халамжийн төвд амьдарч буй хүүхдүүдтэй харилцах томчуудын харилцаа дутагдах заримдаа харилцаа нь оновчгүй байх явдал бий. Энэ нь сургуулийн өмнөх насны хүүхэд асрах байгууллагад ихээхэн хамааралтай. Гэр бүлгүй хүүхдүүдэд тэдгээрийн сул талыг нөхөх арга хэмжээ ихээхэн зохион байгуулж завгүй байлгахыг хичээдэг ч одоо зохион байгуулж буй үйл ажиллагаа бүр хүүхдэд ямар нэг ур чадвар үлдээж байх ёстой. Хүүхдийн чөлөөт цагийн арга хэмжээнд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- Тухайн насны хамгийн их сонирхдог зүйл байх ёстой.
- Хүүхдийн хувийн онцлог байдал, сонирхолыг харгалзаж үзнэ.
- Хүүхдийн нас нэмэгдэх, бүтээлч үйл ажиллагаа хөгжих тусам үйл ажиллагааны хэлбэр, агуулга хүндэрч өөрчлөгдөж байна.
- Нийгмийн ач холбогдолтой байх.
- Тавьсан зорилгыг биелүүлэхийн тулд хүмүүжлийн ажлыг төгөлдөржүүлэх

Хүүхдүүдийг аливаа үйл ажиллагаанд оролцуулахдаа нэг удаагийн арга хэмжээгээр хязгаарлах биш ажлаа ойрын болон урт хугацаанд төлөвлөж үр дүн үр нөлөөг тооцсон байх шаардлагатай. Хүүхэд нэг бүрийн ур чадварыг дээшлүүлэх үр дүнд суурилсан хөгжлийн хөтөлбөр бидэнд дутагдаж байгааг бидний судалгаанд оролцсон хүүхдийн ур чадвар үе тэнгийн хүүхдийн ур чадвараас бага байгаа нь илэрхийлж байна.

НОМ ЗҮЙ

[1] “Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандарт MNS5852:2008

[2] Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийлэг шаардлага стандарт MNS5852:2017

[3] БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, “Эцэг эхийн боловсролд зориулсан гарын авлага” 2015он

[4] Смелзер, Н. Социологи

[5] Гидденс, А. Социологи

[6] Хүүхдийн эрхийн конвенц

- [7] Хүүхэд хамгааллын тухай хууль \ 2016 он\
[8] Хүүхдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээ /НҮБ-ын гарын авлагын төсөл/
[9] Детский дом как институте социализации осиротевших детей\Гулина, Лиана димовна 2011год\
[10] Кон, И. С. Социология личности [Текст] / И. С. Кон. – М.: Изд-во «Политиздат», 1967. – 383 с.
[11] Куренкова, О. Е. Формирование социального опыта у студентов педвуза в учебной деятельности [Текст]: дис. канд. пед. наук / О. Е. Куренкова. – Вологда, 2002. – 172 с.
[12] Столяренко, Л. Д. Основы психологии / Л. Д. Столяренко; Ростов на/Д.: «Феникс», 2000. - 672 с.
[13] Морозова, И. В. Детский дом как социализирующая воспитательная система – 2011. – №6. – С. 49 – 54.
[14] Вебер, М. Избранные произведения , 1990. – 808 с.
[15] Теоретические основы содержания общего среднего образования В. В. Краевского, И. Я. Лернера. 2003. – 350 с.
[16] Теоретические основы содержания общего среднего образования В. В. Краевского, И. Я. Лернера. 2003. – 350 с.
[17] Морозова, И. В. Социализация детей-сирот и детей, оставшихся без попечения родителей, в условиях воспитательной системы: метод. рекомендации, 2012. – 12с.
[18] З.Т.Морено 1994, И. Б. Гриншпун, Е. А.Морозова 2000
[19] Мид, М. Культура и мир детства, 1988. – 429 с.
[20] И.В.Дубровина.– Новосибирск: Изд-во «Наука», 1980.– 127 с.